



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛГА

210646 Улаанбаатар хот, Төрийн ордон
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2016.07.22 № 1

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Ж.ЭРДЭНЭБАТ ТАНАА**

Асуулга тавих тухай

Монгол Улсын хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, сургалтын болон сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн хүрэлцээ ямар нөхцөл байдалд байгаа, цаашид дээрх асуудлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараахь асуулгыг тавьж байна.

1. Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн өнөөгийн нөхцөл байдал, хүртээмж, сургууль, цэцэрлэгт хамрагдалтын байдал, аль нэг хэлбэрийн сургалтад хамрагдаж чадахгүй үлдэж байгаа сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн асуудлыг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар;


2. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилт, харах хүнгүй гэртээ үлдэж байгаа бага насны хүүхдийн тус үйлчилгээнд хамрагдалтын өнөөгийн байдал, хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэдийн үйлчилгээ эрхлэх бэлтгэл хангалт, төрөөс олгох санхүүжилтийн эх үүсвэрийн талаар;

3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай" 242 дугаар тогтоолын хэрэгжилт, Үдийн цай хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үдийн хоол, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цэцэрлэг, сургуулийн багш нарын цалинг цаашид нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

4. Сурах бичгийн чанарыг дээшлүүлэх, сурах бичиг хэвлэн нийлүүлэлт, хүртээмж, сурагчийн дүрэмт хувцасны нийлүүлэлтийн талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 -т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсохыг Танаас хүсье.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



М.ОЮУНЧИМЭГ